

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-15</i>
<hr/>	
<i>1. “Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>4-7</i>
<i>2. “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	<i>7-15</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 18-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, С.Бямбацогт, Ц.Мөнх-Оргил, Ж.Эрдэнэбат;  
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг. “Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

**Д.Тогтохсүрэн:** “Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хуулийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах референт Ж.Оюунгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан

ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референтийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Наранцэцэг нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай асуудлыг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Н.Энхболд нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Т.Доржханд, Ц.Мөнхцэцэг нар үг хэлэв.

*Байнгын хорооны дарга Н.Энхболд 13 цаг 03 минутаас хуралдааныг даргалав.*

**Н.Энхболд:** 1.“Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 2  
Бүгд: 12  
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 43 минут үргэлжилж, 18 гишүүнээс 12 гишүүн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 10 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр,  
Лхагва гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим, 12 цаг 27 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хурал давхцаад байгаа учраас намайг Байнгын хорооны хурлыг явуулж байгаач гэж чиглэл өгсөн учраас би Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлыг удирдаж явуулахаар боллоо.

Байнгын хорооны хуралд хүрэлцэн ирвэл зохих 18 гишүүнээс одоогийн байдлаар 10 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Энэ 10 гишүүнд Занданшатар дарга, Ц.Мөнхцэцэг гишүүн, Сарангэрэл гишүүн, Ганболд гишүүн, Пүрэвдорж гишүүн, Сүхбаатар гишүүн, Оюунчимэг гишүүн, Батсуурь гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Нямаагийн Энхболд дарга гэсэн 10 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ингээд ирцийн шаардлага бүрэн хангаж байгаа тул Байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлын үйл ажиллагаа нээснийг мэдэгдье.

Хурлаар 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт. Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэл хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал хэлэлцэнэ.

2 дугаарт. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай асуудал хэлэлцэнэ. Ийм 2 асуудлыг өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэхээр оруулж байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Алга байна.

**Хэлэлцэх асуудалдаа орёё.  
Сонгогчдын нэрсийн жагсаалт,  
бүртгэл хяналтын дэд хорооны  
бүрэлдэхүүний тухай асуудал.**

1 дүгээрт нь бид хаврын чуулганаар Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль гэсэн 2 хуулийг баталсан. Энэ хуулиар манай Ардчилсан намынхан санал тавьсан. Үүний дагуу энэ Сонгогчдын нэрсийн жагсаалтын түр хороог цөөнхийн бүлгийн гишүүн ахалдаг байя гэдэг ийм хуулийн төсөл орж ирээд, Улсын Их Хурлаар хэлэлцэгдээд, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд өөрчлөлт ороод Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт ороод, Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг цөөнхөөс байна гэдэг ийм хуулийн төсөл батлагдсан. Үүнтэй холбогдуулаад энэ хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж байгаа.

Өмнө нь бол Ганбаатар гишүүн байж байгаад, энэ хорооны бүрэлдэхүүнээс гарсан. Одоо бол 3 гишүүнтэй байгаа Ганболд гишүүн гишүүн бөгөөд дарга хийж байгаа. Пүрэвдорж гишүүн байгаа. Тэгээд Мөнх-Оргил гишүүн байгаа юм. Ингээд Ардчилсан намын бүлгээс санал ирсэн. Би саналыг танилцуулчихъя.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Энхболд танаа. Санал хүргүүлэх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8, Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс хэрэв цөөнх бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн

Бөхчулууны Пүрэвдоржийг чөлөөлж, Дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурийг санал болгож байгаа тул хуулийн хүрээнд шийдвэрлэж өгнө үү гэж байна.

Дэд хорооны даргатай холбоотой асуудлыг бол дэд хороо өөрөө дотроо яриад шийдчихнэ. Дүрэм журам нь тийм байгаа. Одоо бол харин бид нарын хэлэлцэх асуудал бол Пүрэвдорж гишүүнийг гаргаад, оронд нь Батсуурь гишүүнийг оруулъя гэж байгаа юм. 1 гишүүн, 2 дэд хорооны дарга байж болохгүй. Одоо энэ чинь 2 дахь дэд хороо болж байгаа юм. Төсөв дээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо гэж дэд хороо бий. Энэ дэд хорооны даргаар Пүрэвдорж гишүүн ажилладаг. Тийм учраас Пүрэвдорж гишүүн 2 дэд хорооны дарга хийх боломжгүй. Тийм учраас Сонгогчдын нэрсийн жагсаалтын дэд хорооны бүрэлдэхүүнээс Пүрэвдорж гишүүнийг гаргаад, Батсуурь гишүүнийг оруулах ийм тогтоолын төсөл байна. Тогтоолын төслийг та нарт тараасан. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух саналтай гишүүд байна уу. Алга байна. Пүрэвдорж гишүүн санал хэлнэ. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр өнгөрсөн 2020 оноос сонгогдсоноос хойш нэлээн олон Байнгын хороонд, 3 Байнгын хороонд ажиллаж байгаа. Тэгээд Байнгын хорооныхоо гишүүнийхээ хувиар энэ Сонгогчдын нэрсийн жагсаалтын дэд хороонд орсон байж байгаа. Тэгэхээр энэ хүрээнд бас нэлээн ажлууд хийгдсэн. Тэгэхээр энэ ажлыг өөрөөр хэлбэл Төсвийн байнгын хороонд байгаа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга учраас одоо энэ дэд хороонд байгаагаараа тэрний даргаар сонгогдох гээд байгаа юм. Тийм учраас намайг чөлөөлөх нь зөв байх. Тэгээд ер нь бол хуралд их идэвхтэй оролцдог, бүх зүйлд хүрч ажилладаг болохоор бүх ажлын хэсэг, бүх хуулийн хэсэг бүгдэд нь л оруулдаг. Тэгээд дэд хэсгийн хуралдааныг

огт тасалдаггүй учраас ер нь юм болгонд л оруулдаг л даа.

Тэгээд өнөөдөр энэ Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо бол сонгууль дөхөж байгаатай холбоотойгоор маш чухал дэд хороо байгаа. Энэ дээр ялангуяа Сүхбаатар аймгийг олон жилийн туршид удирдаж, энэ аймгийг хөгжил дэвшилд хүргэсэн, дээрээс нь орон нутгийн тэр ирц болон бусад зүйлтэй холбоотой асуудлаар маш сайн мэдээлэлтэй. Тэгээд дээрээс нь тэр анхан шатын санал авалтын хэсгийн хорооноос эхлээд аймгийн болон улсын тэр бүх шатад бүгдийг нь нарийн бүх зүйлээ мэддэг Жамбын Батсуурь гишүүнийг энэ дэд хорооны гишүүнд оруулаад, тэгээд шууд автоматаар даргаар нь сонгогдоно. Тийм учраас ингэж ажилласан нь хамаагүй үр дүнтэй гэж би үзэж байна. Тэгээд Байнгын хорооны гишүүдийг энэ саналыг дэмжиж санал өгөхийг уриалж байна. Баярлалаа.

**Д.Тогтохсүрэн:** Сүхбаатар гишүүн санал хэлнэ. Сүхбаатар гишүүний микрофон өгье.

**Ж.Сүхбаатар:** Энэ дэд хорооны асуудал ингээд анх байгуулагдаж байх үеийн ч гэсэн хэрэгцээ шаардлагыг би мэдэж байна. Би өөрөө 20-оод жилийн өмнө 20 гаруй жилийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Тэгээд энэ сонгогчдын бүртгэл, хяналтын асуудал бол бүр сонгуулийн маш том маргаан булхайтай асуудал болж хувираад, тэгээд энэ нь болохоор бараг яг улаан паспорт солих үе нь 10 жил үргэлжилчихсэн юм. 1997 оны Засгийн газар паспорт солиод л тэгээд л 10 жил болчихсон. Сүүлдээ иргэний бүртгэлийн тогтолцоо нь ч эвдрээд, тэгээд сонгуулийн үеэр юмаа цэгцэлж авъя гэдэг яг тэр үеэр нь улс төрийн оролцож байгаа намууд нь хардлага сэрдлэгтэй асуудал үүсдэг. Тэгээд л тэр хорооны дарга ингэчихлээ, багийн дарга

ингэчихлээ гэдэг асуудал үүсээд, бид нар 2012 оны 2011 онд баталсан Улсын Их Хурлын сонгуулийн хуулиараа тогтолцоонд өөрчлөлт хийсэн юм. Ер нь томоохон реформыг холимог системийг оруулсан. Үүний автомат систем оруулаад, энэ дотроо сонгогчдын бүртгэл, иргэний бүртгэл гэсэн 2 тогтолцоог 1 тогтолцоо руу шилжүүлсэн байхгүй юу. Тэр нь болохоор иргэний бүртгэлд суурилсан сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн тогтолцоог оруулаад, сонгуулийн хороодыг өөрсдөө нэрийн жагсаалт зохиодгоос нь илүүтэй иргэний бүртгэлийн албан ёсны улсын иргэний бүртгэлийн байгууллага нь энийг суурилж явуулдаг болгосон. Ингэснээрээ бол бид нар ер нь нэлээн олон асуудлууд шийдэгдсэн юм. Ингээд давхар санал өглөө, барилаа гээд л нэрийн жагсаалт будилуулдаг асуудлууд энэ 2012 оны сонгуулиас хойш бол цэгцэрч явсан. Гэхдээ л байн байн 1 сэдэв гаргаж ирээд байдаг байхгүй юу. Энэ нэрийн жагсаалт, бүртгэлийг буруу хийчихлээ, ингэчихлээ гээд. Гэтэл энэ нь болохоор ихэвчлэн юу шүү. Батсуурь гишүүнийг аймгийн даргаар ажиллаж байсан учраас өөрөө сайн. Энэ Улаанбаатарын нэг онцлог байдаг юм байна лээ. Мааш их хүн ингээд орон гэргүй учраас шилжилт хөдөлгөөн их хийдэг байхгүй юу. Би жишээлбэл 6 дүүрэгт амьдарч үзсэн хүн шүү дээ. Тэгээд л байнга л хаягаа сольдог байсан байхгүй юу. Тэгээд би тэр нь сайндаа биш амьдралын эрхээр л олон жилийн хугацаанд дүүрэг дүүрэгт л амьдарч байгаа шүү дээ. Тийм хүмүүс чинь Улаанбаатарт бол олон 10 мянгаараа байдаг. Тэр дээр нь хүмүүс зарим шилжиж, өөр газар байр хөлслөөд амьдарч байгаа ч гэдэг юм уу, өөр газар амьдарч байгаа хүн чинь хаягаа зарим үедээ шилжүүлэх боломжгүй, байнга хаягаа шилжүүлээд байхаар их төвөгтэй байдаг байхгүй юу. Хүүхдээ дагаад хүүхдээ нэг газар бас гуйж байгаад тогтвортой нэг газар амьдардаг, тэгээд тэр хорооны даргынхаа бүртгэлд нэг юм байгаад байдаг. Гэтэл тэр чинь заавал

нэг айл юм уу хашаа дээр давхар бичигдэж таардаг байхгүй юу. Зарим нь бол өөрсдөө угаасаа яриад тохирчихсон байдаг. Зарим нь болохоор дараагийн авсан хүмүүс чинь нөгөө хассан хасаагүйг нь мэдээгүй байдаг. Тэгээд ийм байдал бол сүүлийн жилүүдэд энэ асуудал дээр нэлээн тоглолт гараад яриад байдаг юм.

Тийм учраас би зүгээр одоо сонгууль ойртчихсон үед сонгуулийн үеэр ярих биш, иргэний бүртгэлийн ахуй амьдралын үүднээс гэдэг юм уу, олон жилийн хугацаанд үүсчихсэн энэ асуудал дээр Улсын иргэний бүртгэлийн газартайгаа хамтраад, тэр нийслэл дээр яригдаад байдаг юм даа ихэвчлэн. Орон нутагт бол харьцангуй энэ асуудлууд миний мэдээж байгаагаар бол сүүлийн бид нарын 10 жилийн өмнө шийдсэн асуудлын хүрээнд бол бараг цэгцэрчихсэн юм. Одоо тэгэхээр та Батсуурь гишүүн бол наана нь нэг сонгууль ойртуулж байгаад л нэг тийм ингээд л нэрийн жагсаалт будлиулах гэж байна, бүртгэл ингэх гэж байна гэж дуулиан шуугианыг сонгууль болгоны өмнө гаргадаг энэ ярианаас өмнө нэг ийм онцлогууд байна. Тэгэхээр иргэд энэ бүртгэлийн зөрчлөө арилгах тухай асуудлууд гэж ярьдаг. Үнэхээр зарим нь бол бүртгэлийнхээ зөрчлийг арилгадаггүй байхгүй юу. Тэгээд л бид нар чинь хууль яриад л иргэн өөрөө энэ зөрчлөө арилгах ёстой гээд л.

Тэгтэл зарим айл нь эргээд л манай гэрийн нэр дээр баахан хүн биччихсэн байна ч гэдэг юм уу. Тэгээд тэр нь бол санаатай юу, санамсаргүй юу гээд л. Энийг нь бол урьдчилж сонгогчдын бүртгэл, хяналтын дэд хороо ер нь бол наана нь бол жоохон үзмээр, хармаар байгаа юм. Тэгэхгүй болохоор ингээд яг сонгууль орж ирчхээд л нэг нам нь тэгэх гээд байна, энэ нам нь тэгэх гээд байна гээд. Одоо бол ер нь иргэний бүртгэл дээр суурилсан тогтолцоотой болсон учраас ер нь суурь юм нь бол гайгүй болчихсон байхгүй юу. Хэдэн тийм тодорхой хэмжээний асуудлууд бол гардаг. Гэхдээ тэр 2012 оны сонгуулиас

өмнө гардаг байсан асуудлууд бол иргэний бүртгэл дээр суурилсан тогтолцоо болоод ингээд цэгцэрчихсэн байхгүй юу.

Бүр инээдтэй юм болж байсан шүү дээ. 2004 оны Их Хурлын сонгуулийн үеэр би хөдөө Төв аймагт ажиллаж байхад Алтанбулаг сум дээр билүү дээ. Одоо дарга аа, ингээд нөгөө мөнгө байхгүй тэр үед болохоор тэгээд яасан гэсэн чинь өрхийн бүртгэлээ янзалж чадаагүй байсан. Одоо нэг сонгуулийн хорооныхоо зардлаар иргэдийнхээ юмыг янзалж авъя гэдэг л байсан байхгүй юу. Бүүр ийм хэмжээнд байсан шүү дээ манайхан. Юм бол хөгжиж байгаа. Бүртгэлийн төгөлдөршил гээд Улсын бүртгэлийн тогтолцоог шинэчлэх ажлууд бол 2007 оноос Засгийн газар нэлээн явуулсан. Одоо манай Их Хурлын дэд дарга Мөнхбаатар ч гэсэн энэ дээр ажиллаж байсан жишээлбэл. Тэгэхээр энэ мэтийн юмнуудыг бас урд хойдохоо бодоод сонгууль ойртсон үед одоо дахиад нэг нэрийн жагсаалт, бүртгэлийн луйвар гэж ярихаасаа өмнө энэ иргэний бүртгэлийнхээ юмтайгаа өөрсдөө танилцаарай. Бэлтгэл хангахад нь анхаараарай гэж бүр зориуд Батсуурь гишүүнд хэлье. Бас аймгийн дарга байсан хүн ер нь бол бас бүртгэл мэднэ. Гэхдээ нийслэлийн нэг тийм жоохон онцлогтой юм байгаа шүү. Бас нэг ахуй амьдралтай холбоотой ч гэдэг юм уу.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулъя. Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Дэмжье. Санал санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 81,8 хувь нь дэмжиж, уг санал дэмжигдлээ.

Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн

талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Ингээд 1 дүгээр асуудал хэлэлцэж дууслаа.

12.40 цаг.

**2 дугаар асуудалдаа оръё.**  
**“Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Сонгуулийн хорооны хүмүүсээ дуудаарай. Ажлын хэсгээ эхлээд танилцуулчихъя. Пүрэвээгийн Дэлгэрнаран Сонгуулийн ерөнхий орооны дарга, Дугардоржийн Баяндүүрэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга, Жамъяншаравын Оюунгэрэл Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах референт гэсэн ажлын хэсэг байна. Одоо ингээд Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай асуудлын танилцуулгыг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Пүрэвээгийн Дэлгэрнаран танилцуулна. Дэлгэрнаран даргыг урьж байна. Ажлын хэсгийн 2 номер.

**П.Дэлгэрнаран:** Улс төрийн намын тухай хууль хэрэгжиж эхэлж байгаатай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын хуулийг дагаж Сонгуулийн төв байгууллагын хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ нэмэлт, өөрчлөлтөөр Сонгуулийн төв байгууллагад Улс төрийн намын хуулийн хэрэгжилтээр 10 төрлийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчлагдаж байгаа. Тэгээд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх хуулийн хугацаанууд бол 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс Улс төрийн намын хуулийн хэрэгжилтийн хугацаа эхэлж байгаа. 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хурлын сонгуулийн дараа буюу 2024 оны 7 дугаар сараас эхэлж Улс төрийн



намын хуульд тусгагдсан чиг үүргүүд, намын санхүүжилт, санхүүжилтийн хяналт, төрөөс үзүүлэх дэмжлэг гээд энэ хэсэг бол улс төрийн 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр бий болсон энэ нөхцөл байдал дээр тооцогдож, төлөвлөгдөж, 2025 оны төсөвт тусгагдаж, 2025 оноос төрөөс үзүүлэх дэмжлэгүүдийг бүх талын дэмжлэгүүдийг үзүүлж эхлэхээр хуулийн хугацааг ингэж заасан байгаа. Тэгээд энэтэй холбогдуулаад бэлтгэл ажлыг хангах, төлөвлөлтийг хангах, Сонгуулийн төв байгууллагын ажлын алба буюу нэмэлтээр хуульд орсон өөрчлөлтөөр Тамгын газар гэж нэршилтэй болж байгаа. Энэ Тамгын газар дээр улс төрийн намын чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц орон тоонуудыг нэмэх зайлиггүй шаардлага бий болж байгаа. Тэгээд ингээд бид бол 2024 оны улсын төсөвт орон тоог нэмэгдүүлснээр тооцож төсөвлөсөн. Сангийн яам бол хянаад уг төсвийн нэмэгдсэн орон тооны хэсгийг бол хянаж хассан байгаа.

Гэхдээ хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс бид орон тооны дээд хязгаарыг бол зайлиггүй батлуулах шаардлагатай гэж үзэж байгаа. Улс төрийн намын батлагдсан хуулийг дагаж төв байгууллагын хуульд орсон өөрчлөлтөөр Сонгуулийн төв байгууллагын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэж Улсын Их Хурал тогтооно гэж заасны дагуу бид та бүхэнд тогтоолын төслийг өргөн барьсан юм. Хянан үзэж шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

**Д.Тогтохсүрэн:** Дэлгэрнаран даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулсан. Танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүдийн нэр авъя. Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Ганболд гишүүн.

**Г.Ганболд:** Шинэ хуулиар бол зайлиггүй улс төрийн намын санхүүжилт

хяналт хийх эрх бол Сонгуулийн ерөнхий хороонд оногдож байгаа. Үүний дагуу бол мэдээж бүтэц орон тоогоо нэмэгдүүлэх нь бол зайлиггүй. Их Хурал болбол дээд хязгаарыг нь тогтоох юм байна. Таны хэлснээр бол 2024 оны төсөв дээр байхгүй гэж ойлголоо. Тэгээд би зүгээр яах вэ, бүтцийг дээд хязгаар тогтоосноор бүгдийг нь аваад ажиллуулна ч гэсэн үг бас биш байх. Хууль хэрэгжүүлээд явахаар яг ямар чиглэлийн чиг үүргүүд нь чухал байна гээд бүтцэдээ өөрчлөлтийг зайлиггүй хийх шаардлага байх байх гэж бодож байна. Одоо энэ бүтцээс харах юм бол дотоод аудитын нэгж гээд танай дотоодын л асуудал шүү дээ. Энэ дээр заавал та хэд 50 хэдэн хүнийг хянахын тулд 3 хүн сууж байхын хэрэг байна уу. Томоохон аж ахуйн нэгжүүд хүртэл дотоод аудит чинь ганц нэг хүн байгаа шүү дээ. Тэгээд би бол энэ дотоод аудитын нэгж 3 хүн бол их байна гэж харж байна.

2 дугаарт нь улс төрийн намын мэдээлэл арга зүйн газар 12 хүнтэй. Ер нь улс төрийн намууд өөрсдөө хажуудаа томоохон хуулийн хэлтэс, газруудтай. Барагтай л Сонгуулийн ерөнхий хорооноос улс төрийн намын арга зүйн зөвлөгөө аваад байх юм нь бол хэр бол доо. Тэгэхээр одоо яг энэ дээр 12 хүний бүтэц байгаа нь хэр оновчтой бол. Зүгээр би бүтцийн хувьд ярьж байна шүү. Энийг хэдүүлээ ярьж байгаад зарим газрууд руу нь шилжүүлээд, тоог нь нэмж болно шүү дээ. Тийм ээ. Одоо мэдээлэл сургалт, сурталчилгаа бол хамгийн чухал. Одоо бол сонгогчдын сонгуулийн боловсрол олгох асуудал бол их чухал байгаа байхгүй юу улсын хэмжээнд. Тэгэхээр зүгээр би зарим тоог нь сургалт сурталчилгаа руу нь арай ахиу тавиад явбал арай оновчтой юм биш үү гэсэн. Тэгэхээр энэ дээр та нар яг ямар бодолтой байгаа вэ. Энэ бүтцүүдээ хийхдээ одоо яг шинэ хуулийн дагуу мэдээж та нар өөрсдөө тооцоолж хийсэн байх. Тэгээд энэ дээр зүгээр миний саналууд дээр та ямар бодолтой байна вэ гэдгийг л асууя.

**Д.Тогтохсүрэн:** Дэлгэрнаран дарга хариулт өгнө. Ажлын хэсгийн 2 номер.

**П.Дэлгэрнаран:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Ер нь бол аргачлалын хувьд бол тантай санал нэг байна. Бид нар бол орон тооныхоо дээд хязгаарыг тогтоогоод, бас яг энэ төв байгууллагын тухай хуулиар ч гэсэн бас заагдсан. Сонгуулийн төв байгууллага, дотоод орон тооныхоо зохицуулалт, төсвийн зохицуулалтуудаа өөрсдөө шийдвэрлэх ийм бүрэн эрхтэй байгаа. Тэгээд энэ хүрээнд бол ажлынхаа оновчтой байдлыг тогтоож чиг үүргүүдийг нарийвчилж тогтоогоод, тэгээд энэ орон тооны бүтцийн нэгжүүдийг хооронд нь бол гүйлгэх асуудлыг хийж болох байх гэж бодож байна. Тантай санал нэг байна гишүүн ээ.

**Д.Тогтохсүрэн:** Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Би энэ тогтоолыг бол дэмжиж байгаа юм. Тэгээд гишүүддээ ойлгуулах үүднээс юм хэлмээр байгаа юм. 2005 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн төслийг би Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга байхдаа өөрөө боловсруулж, Улсын Их Хуралд тухайн үед батлуулж байсан юм. Өөрөө бүр Латви, Литва, Украин, тэгээд бусад улс орнууд гээд цөөн тооны бас орнууд Төв байгууллагын тухай хуультай байсан юм. Тэгээд Үндсэн хуульд заасан Сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг Үндсэн хуулийн цэц хянана гэсэн агуулгаа ч харсан. Ер нь Үндсэн хуулийн хүрээнд ийм хүчтэй бай байгууллага байх нь зүйтэй юм байна гэж ингэж хуулийг хийсэн. Сая Тогтохсүрэн гишүүн, Мөнхцэцэг гишүүн нарын хүмүүс маань Сонгуулийн төв байгууллагыг улам хүчтэй болгох чиглэлд нь сая чиг үүргийг нь нэмээд, улс төрийн намын реформоор 2019 онд Зандаа дарга байж байна. Энэ Улс төрийн намын дотоод ардчилал үйл ажиллагааг

хөгжүүлэх тухай заалт хийсний хамгийн том хэсэг бол реформын үргэлжлэл одоо явж байгаа. Тэгэхээр энэ Сонгуулийн төв байгууллага бол ийм загваруудтай юм. Шүүхийн хандлагатай сонгуулийн төв байгууллага, Засгийн газрын хандлагатай сонгуулийн төв байгууллага, Намуудын хандлагатай сонгуулийн төв байгууллага, Холимог хэлбэрийн мэргэжлийн биеэ даасан хүчтэй сонгуулийн байгууллага гэсэн ийм байгууллагууд байдаг. Манайх бол хуучин бол намуудын хандлагатай байсан юм. Одоо тэрнээсээ улам бүр салж бас нэг сөрөг хүчнийхээ нарийн бичгийн даргыг бид нар 2005 оны тэр хуулиасаа хойш сөөлжилдөг ч гэдэг юм уу, Ардчиллынх нь юмыг нь бас сайжруулаад, потенциалыг нь сайжруулаад, автомат системийн хууль гаргаад ингээд хөгжөөд хэдий шүүмжлэлд өртөөд байгаа ч гэсэн өмнөх шүүмжлэлүүдээс ингээд сонгууль сонгуулиар багасаад л бас яваад байгаа юм. Сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөөд. Тэгэхээр сонгуулийн ардчилал, парламентын ардчиллыг хангах хамгийн том байгууллага бол дундын ийм хүчтэй биеэ даасан байгууллага байгаа. Тэгэхээр одоо улс төрийн намуудын төлөвшил бүх юмнаас хоцрогдчихсон юм. Сонгуулиудын асуудлуудыг бид өөрчилж байна. Их Хурлынхаа юмыг өөрчилж байна. Олон юмаа өөрчилж байна. Намууд хоцрогдчихсон байгаа юм. Тэр намуудын энэ хоцрогдлыг бид яаж нөхөх вэ гэхээр Өмнөд Солонгос бол маш хүчтэй байдаг байхгүй юу. Улс төрийн намуудын булхайтай тэр дотоод сонгуулийг нь хүртэл хажуугаас нь зохицуулж өгч байсан байхгүй юу. Солонгост чинь авлига мөнгөний асуудалд намуудын ялзралын асуудал 90-ээд онд автчихсан байсан. Ингээд сонгуулийн байгууллагаа хажуугаар нь оруулж, цэвэрлэх цэгцлэх ажилд нь тусалж байсан.

Тэгэхээр манайх яг энэ зүг рүү л ер нь яваад байгаа юм. Одоо ингээд мэргэжлийн, биеэ даасан хандлагатай гээд. Тэгэхээр тухайн үед одоо Өмнөд

Солонгост сонгуулийн комисс дээр би 2003 онд очиж байхад чинь манай Төрийн ордон шиг байртай, 200 гаруй хүн ажилладаг ийм л байгууллага. Тэд бол цэргийн дэглэмээс парламентын ардчилал руу шилжилтийг хийж маш хүчтэй энэ сонгуулийн өчнөөн юмыг цэгцэлсэн байхгүй юу. Тэдний шийдвэр бол тэгэхдээ аймаар л даа. Яагаад гэвэл сонгуулийн гаргасан шийдвэрийг нь бусад нь хянадаггүй байхгүй юу. Ард түмний хяналтад бид байдаг гэж л бараг даналзаж ярьдаг байсан ийм газар. Зүгээр бид бол мэдээж шүүхийн хяналтад байна. Одоо бид нарын нэг төвөгтэй юм нь сонгуулийн төв байгууллага, шүүх 2 сонгуулийн маргааныг хуваалцан хэрэгжүүлэх асуудал дээр бол олон жил ээдрээтэй явж байгаа. Сүүлийн үед арай л гайгүй байх шиг. Би бол тэр талаар олон жил ажиллахдаа бол шийдлийг нь бүр хүн гаргаж чадаагүй. Энэ дээр маргаан үүсдэг. Шүүхэд хамаагүй өгчихвөл улс орнууд юу гэвэл шүүх сонгуулийн үр дүнг шийдчих гээд байдаг. Тэгэхээр Франц мэтийн орнууд бол Үндсэн хуулийн зөвлөл гээд шүүхээсээ тусдаа авч, дотоод хүрээндээ Герман эд нар бол парламентын хүрээндээ шийдэх хандлага руу ороод байдаг.

Тэгэхээр бидний хувьд бол Сонгуулийн төв байгууллага дээр бол нэг том алхам хийчихсэн. Улс төрийн намын тухай хууль санхүүжилтэд нь хяналт тавина. Дотоод ардчиллынх нь юманд нь ер нь оролцоно. Ингээд төр бол улс төрийн намуудын төрийн бус байгууллагын хэмжээнд биш, нийтийн ашиг сонирхлын үүднээс төр өөрийнхөө гар хөлийг орж олон нийтийн эрх ашгийн үүднээс зохицуулалт хийдэг механизмыг оролцуулах боломж ганцхан шүүхээр болохгүй байсан учраас Сонгуулийн төв байгууллагаар дамжиж хийх гэж байгаа юм. Тэгэхээр энэ болгонд бид мэргэшсэн суурь үндсийг нь тавих гээд байгаа байхгүй юу. Санхүүжилт талаас нь, хүн хүч талаас нь, боловсон хүчин талаас нь. Энэ бол он жилүүдийн бид нарын

ардчиллын хувьд оруулж байгаа том хөрөнгө оруулалт болно шүү. Шүүхдээ 8 жил хөрөнгө оруулалт 0 тавьдаг шиг, сонгуулийн байгууллагадаа том ажил гээд хариуцуулчхаад мөнгийг нь, орон тоог нь нэг шийдээж өгөхгүй байх юм бол инээдэмтэй болно. Тийм учраас энийг ойлгож одоо бид хандах шийдэх ёстой юм.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Манай Сүхбаатар гишүүн үг хэллээ. Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Миний саналыг бараг хэлчихлээ. Түрүүн нөгөө Ганболд гишүүний хэлсэнтэй адилхнаар би бас энэ бүтцийг харж байна л даа. Тэгээд угаасаа Сонгуулийн ерөнхий хороо, энэ төв байгууллагыг хүчтэй байлгах, бие даасан байлгах, сонгогчдын эрхийг хамгаалах, тэдний сонголтыг хүндэтгэх, тэгээд энэ нь өөрөө эргээд парламентын ардчилал, төрийн тогтвортой байдал гээд олон талаасаа бол энэ үндсэн энэ сонгуулийн төв байгууллага өөрөө хүчтэй бие даасан байх явдал байгаа. Тиймээс энэ орон тоог хуулиа хэрэгжүүлэхийн тулд мэдээж хүний нөөц хэрэгтэй. Зөв боловсон хүчин, бүтэц зохион байгуулалт чухал. Тэгэхээр энийгээ дагаад санхүүжилтийн асуудлыг нь уг нь 2024 оны төсвөөс эхлээд тодорхой хэмжээгээр шийдээд явах нь бол зөв шүү дээ. Нэгэнт бид хууль гаргасан юм бол энэ хуулиа хэр хэрэгжүүлэх ёстой. Хууль хэрэгжүүлэхэд хүний нөөц хэрэгтэй. Хүний нөөц нь өөрөө санхүүжилттэй байж байж л энэ асуудал явна. Тэгэхээр эхний ээлжид тодорхой хувь хэмжээгээр энэ санхүүжилтээ бас шийдүүлбэл яасан юм бэ. Хэрвээ одоо сая хэлж байна байна. Хэт том бүтэц бий болгохоос илүүтэй энэ он гараад Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн хууль гээд энэ бүхнийг хэрэгжүүлээд яг бие даасан байдлаар ажиллахад та бүхэнд хэчнээн орон тоо энд нь бол зүгээр эхний шатлал гээд байгаа шүү дээ. Дээд босго гээд байгаа. Ямар ч байсан зайлшгүй энэ хуулиа хэрэгжүүлэхэд ийм орон тоо уг нь

шаардлагатай, үүний дагуу санхүүжилт нь ийм хэрэгтэй гэсэн тооцоо судалгаа та бүхэн маань гаргасан л байгаа байх даа. Энэ талаар нэг товч мэдээлэл өгөөч.

Тэгээд түрүүний Ганболд гишүүний хэлдэг тэр мэдээлэл сурталчилгаа буюу иргэд рүү хандсан зөв мэдээлэл өгөх. Тэгэхгүй бол заримдаа олон нийтийн сүлжээ манайд бас хууль, эрх зүйн ямар ч зохицуулалт байхгүйгээс болоод сонгуулийн дараа элдэв асуудал үүсэх вий гэсэн болгоомжлолууд жишээ нь зөндөө яриад байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар энд өөрөө юу вэ гэхээр сонгуулийн төв байгууллага аль ч намаас хараат бусаар, тэгээд өөрсдөө энийгээ сонгогчдын эрхийг хамгаалж, сонгогчдын сонголтыг хамгаалж энийгээ хийгээд байж байх бүрэн чадвартай байх ёстой л доо. Энэ нь өөрөө энэ хууль хэрэгжүүлэх гол үндэс байна. Тэгэхээр энэ дээр нэг мэдээлэл өгчих үү гэж хэлмээр байна. Тэгээд мэдээлэл сурталчилгаандаа илүү их анхаараарай. Хүний орон тоон дээрээ гэж хэлье.

**Д.Тогтохсүрэн:** Дэлгэрнараран дарга хариулт өгнө. Ажлын хэсгийн 2 номер.

**П.Дэлгэрнараран:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Таны саналтай бас бид нар нэг байна. Таны бас хэлсэн анхааруулсан зүйлүүдийг бол зөвлөмж гэж бид нар бас хүлээж авч байна. Тэгээд ер нь бол хуулийн хэрэгжилтийн хугацаа 2024 оны 1 сарын 1. Тэгэхээр хуулийн хэрэгжилтийн хугацаа эхлэхээс өмнө бол бид нар бэлтгэл ажлаа хангаж, орон тоо, хүний нөөцийнхөө асуудлыг шийдэж бэлдэх нь зөв гэдэг утгаар бид нар орон тооныхоо дээд хязгаарыг тогтоолгож авъя гэж байгаа. Тэгээд хуулийн хэрэгжилтийн хугацаа маань бол бас хэд хэдэн үе шаттай. Тэгээд тэр 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр бий болсон нөхцөл байдалтай уялдуулж нөгөө төрөөс үзүүлэх дэмжлэгүүд, санхүүгийн хяналт гээд энэ функцийн ажлууд бол энэ

сонгуулийн дараа хийгдэж, төлөвлөлтүүд хийгдэх ёстой, гүйцэтгэлүүд хийгдэх ёстой. 2025 оны төсөв дээр бид нар бол төрөөс үзүүлэх санхүүжилтийг бүрэн тусгаж явах ёстой. Тэгэхээр энэ 2024 онд төсвийн төслийг хийж батлуулах асуудлаас авхуулаад энэ асуудал дээр хариуцсан хүмүүсийг нь бид нар бас мэргэшүүлж сургаж, тэгээд хуульд заасан шаардлагын дагуу бид нар томилж бэлэн болгох ийм шаардлагатай байгаа.

Тийм учраас бид нар 2024 онд бол бид нар төсвөө орон тоогоо нэмсэн байдлаар бид нарт бид нар бол төсвөө хийж явуулсан. Сангийн яам бол хянахаар энэ тогтоол гараагүй үед бол нэмсэн талын хэсгийг бол хасна гээд ингээд хассан байгаа. Тэгээд бид нар бол хамгийн гол нь хуулийн хэрэгжилтийн хугацаа бол бас нэлээн хэд хэдэн үе шаттай учраас бид нар энэ дээд хязгаараа тогтоолгоод л, шууд эндээ тулгаад л бүгдийг нь томилж ажиллуулна, бүх зардлыг бол ингээд бүтэн хэмжээгээр авна гэхгүй энэ чинь үе шаттай явах учраас ингээд одоо шийдэж өгөөч гэж бид нар хүсэлт тавьж байгаа юм.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу. Түрүүн бараг үг хэлчихсэн дээ. Доржханд гишүүн үг хэлнэ. Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ. Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Доржханд гишүүн үг хэлнэ.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тогтоолын төслийг бол дэмжиж байна. Тэгээд 2024 оны сонгууль бол маш чухал цоо шинэ эрх зүйн орчинд, дээрээс нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүн гарах ийм сонгууль байгаа юм. Тэгээд маш том ийм шинэчлэл хийсэн болохлоор яг үүний бас тодорхой ачаа нь бол Сонгуулийн ерөнхий хороо дээр ирж байгаа нь маш ойлгомжтой байгаа. Тэгэхээр ямар зүйл хэлмээр байна гэхээр энэ удаагийн сонгуульд маш өөр орчинд

явж байгаа болохлоор иргэдэд мэдээлэл өгөх ийм ажил бол зайлшгүй шаардлагатай байна. Өөрөөр хэлэх юм бол яг энэ пропорциональ элемент гэж юу юм бэ. Хэдэн хувьд нь очих юм. Намаа сонгох юм уу, хүнээ сонгох юм уу гэдэг энэ ойлголт иргэдэд байхгүй байна. ХҮН намын зүгээс бид нар сумаа өрнөөс чөлөөлье гээд аяныг бүх сумуудаар ингээд хийгээд явж байгаа. Иргэдтэй уулзаад явж байхад ямар ч мэдээлэл байхгүй, ойлголт ч алга. Тэгээд ийм болохлоороо энэ мэдээллүүдийг одоогоос эхэлж өгөх хэрэгтэй байна. Тэгэхээр 2024 оны төсөв дээр бол мэдээж төсвийг нь суулгаад тэгээд энэ тогтоолынхоо дагуу бол бүтцээ сайжруулаад л явах л байх л даа. Гэхдээ наана нь та бүгд ингээд ажил руугаа орохгүй бол нөгөө том тогтолцооны өөрчлөлтийнхөө үр дүнг иргэд нь мэддэггүй, тэгээд мэдээллийн зөрүүтэй байдлаас болоод хүлээгдсэнээс өөр үр дүн үүсчих вий гэдэг ийм бас болгоомжлол үнэхээр бодитой байна. Үнэхээр бодитой байна.

Тэгээд Улс төрийн намын тухай хууль мөн адилхан бас өөрчлөгдсөн байгаа. Тэгээд бид нар бүгдээрээ л ажлын хэсэг гээд явсан. Би бол сайн өөрчлөлт болсон гэж бодож байгаа. Мөн тодорхой бас шийдвэрүүд, зохицуулалтууд бол сонгуулийн төв байгууллага дээр бол ирсэн байгаа. Тэр нь ч зөв гэж бодож байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бас улс төрийн намууддаа мэдээллийг нь өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүй улс төрийн намууд чинь бас мэдээлэлгүй яваад байна. Ямар өөрчлөлт болчихсон юм, ямар зохицуулалтууд байгаа юм бэ гээд. Тэгэхээр яг ийм чиглэлээр та бүгд маань сургалтуудаа маш сайн хийгээд, мэдээллээ хийх байдлаар явах хэрэгтэй байна. Тэгээд 2024 оны төсөвтөө бол яг энэ иргэдээ соён гэгээрүүлэх, тэгээд ирэх жилийн сонгуулийн бөгөөд мөн Улс төрийн намын тухай холбогдох хууль, эрх зүйн орчны өөрчлөлтийн талаар мэдээллүүдийг яаралтай хүн болгонд өгөөч ээ. Зөвхөн цахим орчин хэвлэл

мэдээллийн байгууллага гэхээсээ илүү бас нөгөө бүтэц дотроо энэ сургалтын нэгж 12 сургалт судалгааны төв гээд орон тоо оруулж ирж байгаа бол энэ хүмүүсийгээ яаралтай бас зохион байгуулалтад оруулаад, аймаг, орон нутгуудаар, тэгээд хороодоор явуулж мэдээллийг нь өгөх ийм шаардлага байна л гэж харж байгаа юм.

Тэгээд эцсийн эцэст бол Монгол улс бол Ардчилсан улс. Тэгээд сонгууль маань ардчилсан журмаар явах ёстой. Тэгэхийн тулд бүгдээрээ тэгш жигд мэдээлэлтэй байх ёстой. Тэгээд энэ ажил бол яалт ч үгүй та бүгдийн хариуцах ажил юм. Тэгээд ийм болохоор энэ дээрээ анхаараач ээ. Тэгээд холбогдох бас нэг олон улсын байгууллагуудын төслүүдтэй хамтарч ажиллаач гэж хүсээд байгаа юм. Капасити Бьюлдинг гээд НҮБ болон Дэлхийн банк, мөн Европын Холбоо гээд маш олон ийм төслүүд байдаг. Тэгээд Дэлгэрнарар дарга яаралтай хандмаар байна. Тэр хүмүүстээ хамтарч ажилламаар байна. Зөвхөн орон тоогоо нэмэхээс гадна хажууд нь бас зөвлөх үйлчилгээнүүдийг аваад 2024 ондоо бэлдэж ажилламаар байна. Ингэж байж бид нар энэ том цогц реформынхоо үр дүнг бол хамтдаа харна гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр бас анхаарч ажиллаарай гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

**Д.Тогтохсүрэн:** Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн барьсан Улс төрийн намын тухай хуулийн төсөл бол манай улс төрийн салбарын хамгийн том өөрчлөлтийн нэг байсан. Энийг Их Хурал маань батлаад, 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжинэ. Эрх зүйн болон намуудын хувьд бол маш том шинэчлэл шалгуур тавигдаж байгаа ийм чухал өөрчлөлт гарна. Тэгээд намууд бол хуучны 2005 оны болон 1990 оны хуулиар нийгмийн өмнө ямар нэг үүрэг хүлээдэггүй байсан юм тэгээд. Тийм учраас иргэдийн дунд

бол ерөөсөө улс төрийн нам гэдэг бол нэг эрх мэдэлд тэмүүлсэн хүмүүсийн бүлэглэл, бөөгнөрөл. Тэгээд улс төрд гарсан хойноо төсөв, бялуу хуваах ийм институт гэдэг ийм ойлголт 30 жил тогтчихсон. Тэгвэл энийг өөрчлөх гол шинэчлэл бол энэ улс төрийн намын хууль байгаа. Үүнийг хэрэгжүүлэх бодит амьдрал дээр хэрэгжүүлэх, хяналт тавих гол институт бол сонгуулийн төв байгууллага. Тийм учраас бид нар энэ сонгуулийн төв байгууллагын хүний нөөц болон бусад энэ хяналт тавих үүрэг функцийг өргөжүүлэх нь зүйтэй.

Энэ дотор хамгийн чухал хэсэг бол намын санхүүжилтийн асуудал байгаа. Нэг одоо тодорхой баримт хэлмээр байна. Саяхан явагдсан Ардчилсан намын эмэгтэйчүүдийн холбооны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нараасаа 60 саяын дэнчин авсан тухай ийм мэдээлэл яваад байгаа. Улс төрийн намын тухай хуулийн тодорхой заалт дээр 10.1.6-аар бол сонгуульд нэр дэвших эрх олгоходоо намууд гишүүдээсээ болон дэмжигчээсээ барьцаа дэнчин авахыг хориглосон байгаа. Хэрэвзээ ийм тохиолдол үүссэн бол энэ бол Зөрчлийн хуулиар тухайн авсан барьцаа дэнчинг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээний торгуультай байгаа. Гэм нь энэ хууль маань 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжих учраас тэр болтол ингээд зарим намууд сиймхий ашиглаж улс төр дэх хөрөнгө мөнгөний өрсөлдөөнийг бэхжүүлсэн хэвээр байна. Тийм учраас бид нар энэ хуулиа яаралтай хэрэгжүүлж энэ хууль хэрэгжүүлэх хяналт тавих сонгуулийн төв байгууллагыг бэхжүүлэх ёстой.

Тэгээд энэ намын шинэ хуулиар бол улс төрийн намууд зүгээр сонгуульд чиглэсэн цаг зуурын өрсөлдөөн явуулдаг ийм этгээдүүд биш, иргэдийнхээ өмнө үүрэг хүлээдэг иргэдийн улс төрийн боловсролд хөрөнгө оруулдаг, сургалт хийдэг, дээрээс нь намууд дотоод ардчилал хангах ёстой. Энэ бүх үйл ажиллагааг бол улс төрийн намын үйл ажиллагааг бол Сонгуулийн төв

байгууллага хянана. Жишээлбэл та бид нар бүгд мэдэж байгаа шүү дээ. 1990 онд юм уу, 1992 онд байгуулагдаад л байгуулагдсан цагаас хойш 1 ч удаа Их Хурлаа хийгээгүй. Хэн нэгэн Лидерийн халаасны нам гэж манай иргэд яриад байгаа. Ийм намууд зөндөө байна. Энэ намуудыг өөрчлөөч ээ. Энийг өөрчлөхгүй бол Монголын ардчилал явахгүй гэдгийг бол манай олон нийт маш их хэлдэг. Тэгвэл, энийг өөрчлөх, энийг хянах гол механизм бол сонгуулийн төв байгууллага. Тийм учраас сонгуулийн төв байгууллагын хүний нөөцийг болон хяналт тавихыг нь өргөжүүлэх шаардлагатай. Ер нь бол намууд нийгмийн өмнө үүрэг хүлээсэн, бодлогоор өрсөлддөг, дотооддоо ардчилалтай, хүний эрхийн болон эмэгтэйчүүдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ оролцоог хангаж байна уу, үгүй юу гэдэг дээр сонгуулийн төв байгууллага бол байнгын хяналт тавих ёстой. Ер нь бол иргэд олон нийтийн хэлж байгаагаар бол ер нь сонгуулийн жилүүдэд л энэ сонгуулийн төв байгууллага ажиллаад бусад үед тодорхой үйл ажиллагаа хийдэггүй юм шиг харагдаж ирсэн. Тэгвэл одоо энэ намын тухай шинэ хуулиар бол сонгуулийн төв байгууллага байнгын үйл ажиллагаатай мэдээллээ өгдөг. Ялангуяа иргэд, сонгогчдод сонгуулийн үйл явцын талаар улс төрийн боловсролын талаар мэдээлэл өгдөг ийм байгууллага болох ёстой. Тийм учраас Их Хурал шаардлагатай хүний нөөцийн болон төсвийн энэ дэмжлэгүүдийг бол өгөх ёстой.

Тийм учраас энэ тал дээр бид нар дэвшил гаргаж, ер нь энэ Монгол дахь улс төрийн хариуцлага, хөрөнгө мөнгөний өрсөлдөөнийг багасгах, шударга өрсөлдөөний гарааны тэгш байдлыг нам нэр дэвшигчид олгох ёстой. Энэ дээр бид нар анхаарч сонгуулийн байгууллагыг бэхжүүлэх нь зүйтэй гэдэг саналыг хэлмээр байна.

**Н.Энхболд:** Гишүүд нэрээ өгөөд үг хэлээд дууслаа. Одоо санал хураалт

явуулна даа. Зарчмын зөрүүтэй санал гарахгүй бол орж ирсэн төслийг дэмжье гэдэг саналаар санал хураалт явуулна. Санал байхгүй гэж үзээд тогтоолын төсөл танилцууллаа шүү.

“Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай”

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 60 албан хаагчтай байхаар тогтоосугай.

Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны холбогдох төсөв, үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүгийн асуудлыг гэдэг юм уу, зардлын гэдэг юм уу шийдвэрлэх талаар шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм төсөл байна. Саяын уншсан томъёоллоор тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. 12 гишүүнээс, Мөнхцэцэг гишүүнийг протоколд тусгаарай. 10 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ.

Дараа нь “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төсөл. Төрийн албаны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь

Нэг.Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал зэрэглэлийг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 18

дугаар тогтоолын хавсралтын “Сонгуулийн ерөнхий хорооны ажлын алба, төв” гэснийг “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газар, төв” гэж, “тэргүүн түшмэл ангиллын АА-1 зэрэглэлийн ажлын албаны дарга” гэснийг “Мэдээллийн технологийн төвийн захирал” гэж, “АА-2 зэрэглэлийн Мэдээллийн технологийн төвийн захирал” гэснийг Газар, төвийн дарга” гэж тус тус өөрчилсүгэй.

Энэ тогтоолыг 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Дэмжих санал хураалт явуулъя. 12 гишүүнээс 8 нь дэмжиж, минийх орж байгаа шүү тэрийг протоколд тэмдэглэжээрэй. Баярлалаа.

Дараагийн санал хураалт. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 сарын 1-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилхан төрийн албан тушаалтны зэрэглэлийн зэрэг зиндаа ТӨ-4-ийн тусгай албан тушаалд “Авлигатай тэмцэх газрын дарга” гэсний дараа “Сонгуулийн ерөнхий хорооны дарга” гэж, ТӨ-6-ийн захиргааны албан тушаалд “Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга” гэсний дараа “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга” гэж тус тус нэмсүгэй.

2.”Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол

Улсын Их Хурлын 2019 оны 2 сарын 1-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийн зэрэг зиндаа ТӨ-5-ын тусгай албан тушаалын Сонгуулийн ерөнхий хорооны дарга гэснийг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга гэж өөрчилсүгэй.

3. “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 2 сарын 1-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийн зэрэг зиндаа ТӨ-6-гийн тусгай албан тушаалын “Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга” гэснийг хассугай.

Энэ тогтоолыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 12 гишүүн санал өгч, 10 дэмжиж тогтоолын төсөл дэмжигдэж байна.

Үүгээр “Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай” асуудлыг хэлэлцэн дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Мөнхцэцэг гишүүн чуулганд танилцуулчих уу. Мөнхцэцэг гишүүн. Байнгын хороогоор өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

13.10 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ